

193
"Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын
газрын даргын 2024 оны 12 дугаар сарын
20-ны өдрийн 01/11/25 дугаар албан бичгийн
3 дугаар хавсралт"

**МУЗЕЙН 2024 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024.12.20

Булган аймаг

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Музейн 2024 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө" -нд тусгагдсан арга хэмжээний жилийн эцсийн гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч, удирдлагыг бодит мэдээллээр ханган, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж гарган дэмжлэг үзүүлэх зорилгоор үнэлгээг зохион байгуулав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг /Цаашид "Журмын" гэх/ "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийн үр дүн, хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар авч, мэдээлэл авах, нотлох баримт цуглуулах, холбогдох албан тушаалтнаас тайлбар, нэмэлт тодруулга авч тайлагналын чанарыг сайжруулан удирдлага, зохион байгуулалтын болон оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргийг харгалзан журмын 6.2.1-6.2.3-т заасан үнэлгээний аргазүйг ашиглан үнэллээ.

Гурав. Хяналт-шинжилгээний үр дүн

Музейн 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт 44 арга хэмжээ хэрэгжүүлэхээр туссанаас хэрэгжилтийн дундаж 93.03 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 2.5 хувиар өссөн гэж үнэлэгджээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үнэлгээ тус бүрээр үзүүлбэл:

-зорилт, арга хэмжээний хэрэгжилт хүрэх түвшинд хүрсэн, бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарч, гол үр дүн нь гарснаар 90-100 хувиар үнэлэгдсэн 39 арга хэмжээ,

191

-тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувиар үнэлэгдсэн 1 арга хэмжээ,

-тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувиар үнэлэгдсэн 2 арга хэмжээ,

-тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлсэн ч шийдвэрлэгдээгүй байгаа 1 арга хэмжээ "0" үнэлэгдсэн байна.

Түүх, соёлын хөдлөх дурсгалын улсын тооллого хийгдээгүй учир үнэлгээнд оруулаагүй/

Дөрөв. Дүгнэлт

Музейн 2024 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 44 арга хэмжээтэй боловсруулан хэрэгжилтийг 93.03 хувьтай буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээтэйгээр хэрэгжүүлэн ажилласан байна.

ЗӨВЛӨМЖ:

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, тайлагналт:

1. Арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нийцэхүйц тодорхой тайлагнах;

2. Зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг буруу тодорхойлсон, шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшин хоорондоо уялдаагүй, /тухайн арга хэмжээ хэрэгжсэн эсэхийг шалгуур үзүүлэлтийн дагуу хэмжих учраас/ дэвшүүлсэн зорилтын дагуу арга хэмжээг зөв тодорхойлоогүй /харилцан уялдаагүй/;

3. Төлөвлөгдсөн арга хэмжээнд идэвх санаачилга гаргаж заавал оролцох ;

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журам", ЗГХЭГ-ын даргын 2020 оны Аргачлал батлах тухай 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулж, тайлагнах;